

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/62/НА-СТА-ТШЗ

# Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН  
16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
А.ЖАЙНАГУЛ ТАНАА

2024.02.06 № 37  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн Засаг даргын орлогчийн 2023 оны А/520 дугаар захирамжаар цэцэрлэгийн бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 2 бүлэг, 10 орон тоо нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

# Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГУЛ



16-р цэцэрлэг Дүгнэлт-1.30

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,489,766.00</b>	<b>117,546,281.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>105,236,846.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	-	105,236,846.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,875,316.00</b>	<b>2,775,316.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,875,316.00	2,775,316.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>11,614,450.00</b>	<b>9,534,119.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,614,450.00	9,534,119.00
35420	Аж ахуйн материал	510,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	758,400.00	802,974.00
35460	Хүнсний материал	3,767,500.00	3,366,795.00
35470	Бусад хангамжийн материал	6,578,550.00	5,364,350.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>411,034,612.96</b>	<b>413,289,192.01</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>411,034,612.96</b>	<b>413,289,192.01</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>405,774,612.96</b>	<b>406,605,953.01</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	443,736,198.00	450,736,198.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,560,889.52)	(60,123,159.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,721,300.00	19,577,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,631,052.75)	(5,183,304.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,996,146.00	26,996,146.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,764,406.57)	(25,674,544.96)
39217	Ном	277,317.80	277,317.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,260,000.00</b>	<b>6,683,239.00</b>
39301	Програм хангамж	660,000.00	2,083,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(660,000.00)	(660,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,260,000.00	5,260,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>425,524,378.96</b>	<b>530,835,473.01</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>326,125.17</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	326,125.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	59,625.17
41361	Байгууллагад төлөх өглөг	-	266,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>420,264,378.96</b>	<b>530,509,347.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	420,264,378.96	530,509,347.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	5,260,000.00
51101	Өмч: - төрийн	-	5,260,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>412,722,378.96</b>	<b>517,707,347.84</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	412,722,378.96	412,722,378.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	104,984,968.88
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,542,000.00	7,542,000.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>420,264,378.96</b>	<b>530,835,473.01</b>

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>364,712,900.00</b>	<b>649,261,039.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>323,008,100.00</b>	<b>628,904,639.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	323,008,100.00	616,125,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		12,779,239.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,601,300.00</b>	<b>20,356,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,601,300.00	20,356,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>368,462,417.88</b>	<b>544,276,070.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>368,462,417.88</b>	<b>544,276,070.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>368,462,317.88</b>	<b>544,276,070.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>264,300,584.00</b>	<b>394,451,548.53</b>
210101	Үндсэн цалин	237,394,159.00	394,451,548.53
210102	Нэмэгдэл	13,142,771.00	-
210104	Урамшуулал	13,763,654.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,391,800.00</b>	<b>45,940,260.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,761,400.00	45,940,260.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,700.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,126,000.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	531,600.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,315,100.00	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,267,600.00</b>	<b>18,643,826.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,577,900.00	2,808,606.00
210302	Түлш, халаалт	6,889,700.00	14,455,220.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,380,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,837,065.00</b>	<b>57,293,775.00</b>
210502	Хоол, хүнс	41,837,065.00	57,293,775.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>1,668,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	1,668,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>892,900.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	892,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,469,768.88</b>	<b>25,385,759.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,786,000.00	10,675,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,610,000.00	2,686,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,073,768.88	12,024,659.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100.00</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(3,749,517.88)</b>	<b>104,984,968.88</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(3,749,517.88)</b>	<b>104,984,968.88</b>

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>364,712,900.00</b>	<b>636,481,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>323,008,100.00</b>	<b>616,125,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	323,008,100.00	616,125,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,601,300.00</b>	<b>20,356,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,601,300.00	20,356,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>364,712,900.00</b>	<b>529,744,954.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>364,712,900.00</b>	<b>529,744,954.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>364,712,800.00</b>	<b>529,744,954.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>267,175,900.00</b>	<b>386,076,196.00</b>
210101	Үндсэн цалин	222,173,062.00	269,511,774.29
210102	Нэмэгдэл	37,989,100.00	100,942,172.71
210104	Урамшуулал	7,013,738.00	15,622,249.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,391,800.00</b>	<b>54,155,988.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,761,400.00	35,097,888.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,700.00	4,764,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,126,000.00	3,811,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	531,600.00	953,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,315,100.00	9,529,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,704,300.00</b>	<b>18,688,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,577,900.00	3,728,606.00
210302	Түлш, халаалт	7,326,400.00	13,328,500.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,631,294.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,125,100.00</b>	<b>56,893,070.00</b>
210502	Хоол, хүнс	44,125,100.00	56,893,070.00

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>1,668,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	1,668,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>895,400.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	895,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,120,200.00</b>	<b>11,367,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,510,200.00	8,681,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,610,000.00	2,686,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100.00</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>106,736,846.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>1,500,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	1,500,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(1,500,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>105,236,846.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>105,236,846.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	5,260,000.00		416,471,896.84		421,731,896.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,260,000.00</b>	-	<b>416,471,896.84</b>	-	421,731,896.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		7,542,000.00			7,542,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			(3,749,517.88)		(3,749,517.88)
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,260,000.00</b>	<b>7,542,000.00</b>	<b>412,722,378.96</b>	-	425,524,378.96
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,260,000.00</b>	<b>7,542,000.00</b>	<b>412,722,378.96</b>	-	425,524,378.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,260,000.00</b>	<b>7,542,000.00</b>	<b>412,722,378.96</b>	-	425,524,378.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			104,984,968.88		104,984,968.88
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,260,000.00</b>	<b>7,542,000.00</b>	<b>517,707,347.84</b>	<b>-</b>	<b>530,509,347.84</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>636481800.00</b>	<b>531244954.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>636481800.00</b>	<b>531244954.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>636481800.00</b>	<b>531244954.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>482626400.00</b>	<b>386076196.00</b>
210101	Үндсэн цалин	306462700.00	269511774.29
210102	Нэмэгдэл	161152400.00	100942172.71
210104	Урамшуулал	15011300.00	15622249.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60328300.00</b>	<b>54155988.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	41023000.00	35097888.00
210202	Тэтгэмжийн даатгал	4826300.00	4764500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3860900.00	3811500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	965500.00	953100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9652600.00	9529000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18688400.00</b>	<b>18688400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3728606.00	3728606.00
210302	Түлш, халаалт	13328500.00	13328500.00
210303	Цэвэр, бохир ус	1631294.00	1631294.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59407400.00</b>	<b>56893070.00</b>
210502	Хоол, хүнс	59407400.00	56893070.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1668000.00</b>	<b>1668000.00</b>
210604	Урсгал засвар	1668000.00	1668000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>895400.00</b>	<b>895400.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895400.00	895400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12867900.00</b>	<b>12867900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10181800.00	10181800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2686100.00	2686100.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>636481800.00</b>	<b>636481800.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>616125400.00</b>	<b>616125400.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	616125400.00	616125400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20356400.00</b>	<b>20356400.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	20356400.00	20356400.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>105236846.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>36.00</b>	<b>36.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00

# Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

---

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм..

Цэцэрлэг нь “*Сурах, сургах үйлийг дэмжин, хоцрогдлыг арилгаж, хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, чанартай зохион байгуулах*” зорилгын хүрээнд “*Ээлжит хичээлийг чанаржуулах*”, “*Гэрийн даалгавар тогтмол өгч биелэлтийг шалган хэвшил болгох*” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийгдээгүй байна.

Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

## Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105.3 сая төгрөгөөр буюу 125 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	105236.8	105236.8
Авлага	2875.3	2775.3	100.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	11614.4	9534.1	-2080.3
Үндсэн хөрөнгө	411034.6	413289.2	2254.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>425524.4</b>	<b>530835.5</b>	<b>105311.1</b>
Өр төлбөр	0	326.1	326.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	425524.4	530509.3	105.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>425524.4</b>	<b>530835.5</b>	<b>105311.1</b>

Мөнгөн хөрөнгө оны эцэст 105.2 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 105.2 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 102.7 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 2.5 сая төгрөг хүүхдийн хоолны зардлаас үлдсэн мөнгө байна.

Авлага оны эцэст 2.7 сая төгрөг болж оны эхнээс 0.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын үлдэгдэл 9.5 сая төгрөг болж оны эхнээс 2.0 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: хүнсний материалын үлдэгдэл 3.4 сая төгрөг, бусад хангамжийн материал 5.4 сая төгрөг, түлш, шатах тослох материал 0.8 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 413.3 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.5 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 12.8 сая нийт 14.3 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгөд 12.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 0.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 530.5 сая төгрөг болж 105.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 105.0 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

## Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 416.9 сая, орон нутгийн төсвөөс 20.4 сая, нийт зарлагыг 437.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 463.8 сая төгрөгөөр хянаж, 46.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 152.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 616.1 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 18.4 сая төгрөгөөр баталж, тодотголоор 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 20.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 616.1 сая төгрөгийн улсын төсвөөс, 20.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 636.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 616.1 сая, орон нутгийн төсвөөс 20.4 сая нийтдээ 636.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 531.2 сая төгрөг буюу 83.4 хувьтай буюу дансанд 105.2 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	1343.0	1343.0	0	100%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	59407.4	56893.1	2514.3	95.7%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2660.9	2660.9	0	100%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1343.0	1343.0	0	100%
5	Боловсролын стандарт, сургалтын	329056.7	247761.0	81295.7	75.3%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	222314.4	200887.6	21426.8	90.4%
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	20356.4	20356.4	0	100%
	<b>Нийт дүн</b>	<b>636.5</b>	<b>531.2</b>	<b>105.2</b>	<b>83.4</b>

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 106.0 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардлыг 96.5 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6.2 сая, нормативт зардал 2.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 1.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 80.0 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

# Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 368.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө,

## Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой 8.6 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	8600.0	1	8600.0	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>8600.0</b>	<b>1</b>	<b>8600.0</b>	<b>100%</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 10.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

## 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

### 1.1.Илрүүлэлт:

Цэцэрлэгийн цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 10.9 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	10,861.0					1	10,861.0				
Дүн	1	10861.0					1	10861.0				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын хүүхдийн 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								